



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэ Ховд Жаргалант ТҮК ОНӨААТҮГ 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Д.Балжинням
Утас: 88094175
цахим хаяг: DBaljinnyam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	6
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэл.....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Материаллаг байдал.....	9
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	9
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	9
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.03.09 № 02/98
танай _____-ны № _____-т

ШИНЭ ХОВД ЖАРГАЛАНТ
ТҮК ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Д.БУМЦЭНД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ-т Хөшөөт хөгжил сангаас ажилчдын цалин хөлсний зардлыг шийдвэрлэх зорилгоор 262.0 сая төгрөгийг нэмэлт орлогын эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ -ын үйл ажиллагааны орлогын доод, зарлагын дээд хязгаар, ашиг хуваарилах, орон тоо, цалингийн санг ТУЗ-ийн хурлын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга хянаж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлж жил бүр баталж, биелэлтэд хяналтыг хэрэгжүүлэн ажиллана гэж дүрэмдээ заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталаагүй байна.

Гүйцэтгэлээр 614.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 614.9 сая төгрөгийн зардал гарган, 63.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 85 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

021020405

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн хүлээх үүрэг, хариуцлага

Компанийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЯДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,077,089.14</u>	<u>28,039,970.14</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	90,506.14	33,880.14
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	90,506.14	33,880.14
3121	Төгрөг	90,506.14	33,880.14
31213	Арилжааны банк дахь харилцах	90,506.14	33,880.14
34	УРЬДЧИЛГАА	-	700,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	700,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	700,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,950,090.00	27,306,090.00
354	Хангамжийн материал	24,435,590.00	27,306,090.00
35420	Аж ахуйн материал	298,000.00	454,000.00
35470	Бусад хангамжийн материал	24,137,590.00	26,852,090.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>460,814,073.26</u>	<u>387,471,185.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	460,814,073.26	387,471,185.68
392	Биет хөрөнгө	459,564,073.26	386,452,435.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	564,829,900.00	564,829,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(155,598,626.76)	(223,440,611.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,995,000.00	5,995,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(749,375.04)	(1,873,437.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	775,000.00	5,775,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,749.98)	(96,874.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	73,583,100.00	73,583,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(29,232,174.96)	(38,319,639.93)
393	Биет бус хөрөнгө	1,250,000.00	1,018,749.98
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(231,250.02)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>485,891,162.40</u>	<u>415,511,155.82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>36,966,579.65</u>	<u>29,366,771.29</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,966,579.65	29,366,771.29
413	Өглөг	36,966,579.65	29,366,771.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	19,212,649.35	14,852,173.40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,002,015.30	8,947,497.89
4136	Бусад өглөг	10,751,915.00	5,567,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	10,751,915.00	5,195,100.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	372,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>448,924,582.75</u>	<u>386,144,384.53</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	448,924,582.75	386,144,384.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	519,601,465.00	519,601,465.00
51101	Өмч: - төрийн	519,601,465.00	519,601,465.00
512	Хуримтлагдсан үр дүн	(70,676,882.25)	(133,457,080.47)
51210	Өмнөх үеийн үр дүн	(70,676,882.25)	(69,644,128.59)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(63,812,951.88)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>485,891,162.40</u>	<u>415,511,155.82</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	399,575,480.00	635,875,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	136,084,380.00	260,880,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,210,900.00	260,880,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,195,900.00	260,880,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,305,900.00	222,380,459.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,890,000.00	17,000,241.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	21,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263,491,100.00	374,995,050.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	196,212,400.00	374,635,050.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	196,212,400.00	374,635,050.00
1330	Төсвийн захирагчдаас	-	360,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	360,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	469,052,362.25	699,688,701.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	469,052,362.25	699,688,701.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,522,362.25	698,717,701.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,500,482.00	303,913,216.00
210101	Үндсэн цалин	206,471,255.00	292,648,033.00
210102	Нэмэгдэл	10,133,227.00	11,265,183.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,885,743.21	39,796,013.09
210201	Тэтгэврийн даатгал	18,738,224.07	28,145,492.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,319,747.18	2,920,006.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,855,797.76	2,715,815.51
210204	Ажилгүйдлийн даатгал	451,997.64	546,790.87
210205	Эрүүл мэндийн даатгал	4,519,976.56	5,467,908.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,915,015.00	14,077,893.49
210301	Гэрэл, цахилгаан	8,915,015.00	14,077,893.49
2104	Хангамж, бараа материалын зардал	101,672,290.30	154,378,085.72
210401	Бичиг хэрэг	1,405,500.00	2,924,500.00
210402	Тээвэр, шатахуун	86,673,800.30	123,629,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	310,000.00	957,825.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,679,900.00	20,994,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,332,750.00	5,087,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	6,270,340.00	783,900.00
2105	Нормативт зардал	6,969,650.00	2,030,623.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	514,500.00
210502	Хоол, хүнс	426,600.00	1,011,623.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,543,050.00	504,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,362,850.00	42,413,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,757,000.00	32,195,000.00
210604	Урсгал засвар	7,605,850.00	10,218,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,562,000.00	345,000.00
210702	Дотоод албан томилолт	2,562,000.00	345,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,071,440.00	565,365.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,240.00	495,865.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	4,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,200.00	65,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,582,891.74	141,198,505.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,225,500.00	62,855,618.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,357,391.74	78,342,887.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,530,000.00	971,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,530,000.00	971,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	971,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(69,476,882.25)	(63,812,951.88)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(69,476,882.25)	(63,812,951.88)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	20,000.00	-	20,000.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	519,581,465.00	-	519,581,465.00
C07	Тайлант үеийн үр дүн	-	(70,676,882.25)	(70,676,882.25)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,601,465.00	(70,676,882.25)	448,924,582.75
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	519,601,465.00	(70,676,882.25)	448,924,582.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	1,032,753.66	1,032,753.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	519,601,465.00	(69,644,128.59)	449,957,336.41
D08	Тайлант үеийн үр дүн	-	(63,812,951.88)	(63,812,951.88)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,601,465.00	(133,457,080.47)	386,144,384.53

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	399,575,480.00	614,935,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	136,084,380.00	239,940,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,210,900.00	239,940,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,195,900.00	239,940,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,305,900.00	222,940,459.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,890,000.00	17,000,241.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263,491,100.00	374,995,050.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	196,212,400.00	374,635,050.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	196,212,400.00	374,635,050.00
1330	Төсвийн захирагчдаас	-	360,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	360,000.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>393,894,973.86</u>	<u>614,992,376.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	393,894,973.86	614,992,376.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,654,973.86	614,021,376.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202,131,916.00	256,868,665.60
210101	Үндсэн цалин	200,841,916.00	256,868,665.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,580,952.86	78,534,558.78
210201	Тэтгэврийн даатгал	38,580,952.86	78,534,558.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,913,000.00	12,132,410.60
210301	Гэрэл, цахилгаан	1,913,000.00	12,132,410.60
2104	Хангамж, бараа материалын зардал	111,061,380.00	154,516,138.02
210401	Бичиг хэрэг	2,011,000.00	3,142,800.00
210402	Тээвэр, шатахуун	86,314,800.00	140,848,058.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	310,000.00	1,199,459.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,865,580.00	9,325,820.00
2105	Нормативт зардал	24,559,535.00	15,774,738.00
210502	Хоол, хүнс	741,000.00	1,731,623.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,318,785.00	14,043,115.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,524,500.00	81,753,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,005,000.00	70,589,500.00
210604	Урсгал засвар	1,519,500.00	11,164,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,562,000.00	345,000.00
210702	Дотоод албан томилолт	2,562,000.00	345,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	767,440.00	499,865.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	596,000.00	4,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,240.00	495,865.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,554,250.00	13,596,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,554,250.00	13,596,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,240,000.00	971,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,240,000.00	971,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	971,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,680,506.14</u>	<u>(56,626.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	90,506.14	(56,626.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		90,506.14
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	90,506.14	33,880.14

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн зорилго нь тус байгууллагын чиг үүрэгт заасан үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үр ашигтай хэрэгжүүлэн хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан Ховд хотын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд оршино гэсэн зорилго тавин үйл ажиллагаа явуулж байна.

Шинэ Ховд – Жаргалант ТҮК орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ, хог хаягдлыг

цуглуулах, хог хаягдлыг боловсруулах, зайлуулах, хог хаягдлыг дахин ашиглах гэж тодорхойлж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ААТҮГ статустай байна.

Шинэ Ховд – Жаргалант ТҮК орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн сан нь бэлэн 20000 төгрөгөөс бүрдэж байна.

Үйлдвэрлэлийн газар нь хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй, бие даасан тайлан тэнцэлтэй, арилжааны банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн үүрэг хүлээх хуулийн этгээд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хэлбэрээр ажиллана гэж дүрэмдээ заасан байна.

3.2 Үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухайн хууль, Татварын тухай хууль, Аж, ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудыг мөрдөж байна.

Тайлант хугацаанд Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ -ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөгдөж эхэлсэн байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ -ын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, Дотоод аудитын албанаас 2022 онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Үйлдвэрийн газрын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 03 дугаар тогтоолыг үндэслэн бие даасан орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна. 4-д “ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих...” гэсэн заалттай нийцэж байна.

Үйлдвэрийн газрын даргыг зохих хууль тогтоомжид нийцүүлэн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг дарга томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл Засаг даргын бүрэн эрхийн 2 дах заалт “орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох; гэсэн заалтуудтай нийцэж байна.

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөл байгуулсан нь аймгийн ИТХ-ын 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 1.2 дах “орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт тавин ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай” гэсэн заалттай нийцэж байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70.3 сая төгрөгөөр буюу 14.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө	90.5	34	56.5
Авлага	-	700	-700
Бараа материал	24,986	27,306	-2320
Үндсэн хөрөнгө	460,814	387,471	73342.9
Нийт хөрөнгө	485,891	415,511	70,379
Өр төлбөр	36,966.50	29,367	7599.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	448,924	386,144	62780
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	485,891	415,511	70,380

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 90.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 56.5 мянган төгрөгөөр буурсан байна.
- ✓ Авлага 700.0 мянган төгрөгөөр өссөн бөгөөд тайлант онд үүссэн ажилчдаас авах цалингийн урьдчилгааны авлага нь дараа тайлант онд барагдуулан ажиллах боломжтой авлага байна.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 2320.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан бараа материалын үлдэгдэл байна.
- ✓ Үндсэн хөрөнгө өмнөх оноос 73342.9 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.
- ✓ Өглөг данс өмнөх оноос 7599.8 мянган төгрөгөөр буурсан тайлант онд 29367.0 мянган төгрөгийн өр барагдаагүйтэй холбоотой байна.
- ✓ Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч данс нь хуримтлагдсан элэгдлийн зардал нөлөөлжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ -ын үйл ажиллагааны орлогын доод, зарлагын дээд хязгаар, ашиг хуваарилах, орон тоо, цалингийн санг ТУЗ-ийн хурлын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга хянаж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлж жил бүр баталж, биелэлтэд хяналтыг хэрэгжүүлэн ажиллана гэж дүрэмдээ заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталаагүй байна.

Тайлант онд тухайн байгууллагын арилжааны банкны дансаар Хөшөөт хөгжил сангаас санхүүгийн дэмжлэг 262.2 сая төгрөг, Жаргалант сумын ОНХС-аас хур хог хаягдал отводлох 70.0 сая төгрөг, хог хаягдал ялгах сав хийх 5.0 сая төгрөг, бульдозерийн засвар 11.7 сая аж ахуйн нэгж, хог хаягдал зайлуулах ажлын дэмжлэг 26.1 сая төгрөг, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлого 239.9 сая төгрөг нийт 614.9 сая төгрөгийн бүрдүүлэн, 614.9 сая төгрөгийн зардал санхүүжүүлэн ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ -ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Балжинням 2022 оны 03 дугаар сарын 10-наас 03 дугаар сарын 13-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 469.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 166 мэдээллээс 121 мэдээллийг хугацаандаа оруулсан 45 мэдээллийг хугацаа хоцроосон бусад мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100
Нийт дүн	1	0.0	1	0.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэлийн дагуу 38210 кодтой хог хаягдлыг боловсруулах, 38300 кодтой хог хаягдлыг дахин ашиглах, 39000 кодтой хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ үзүүлэх зэрэг чиг үүргийн үйл ажиллагаагаа бодлогын түвшинд хэрэгжүүлэх төлөвлөгөө, стратеги боловсруулан ажиллаагүй зөвхөн хог хаягдал ачиж зайлуулах чиглэлийг барьж ажиллах бол ижил чиг үүрэг бүхий Хот тохижилтын газартай нэгтгэж орон нутгийн төсвийн хөрөнгийн зардлыг бууруулж, үр дүнг тооцож ажиллах чиглэлийг ТЭЗ хүргүүлэн ажиллах тал дээр анхаарах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд залруулга хийх алдаа¹ илрээгүй болно.

Аудитаар 34.4 сая төгрөгийн өглөг барагдуулан ажиллах, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.

5.2. Зөвлөмж

1. Авлага, өр төлбөрийн тооцооны данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1 Өр төлбөрийн дэлгэрэнгүй бүртгэлийг тооцоо нийлсэн акттай тулган шалгахад тайлант оны ажил гүйгээ, гэрээ хэлцлийн хүрээнд бий болсон бусдаас авах авлагын төлбөр тооцоог харилцагч байгууллага бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 5.1 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлээгүй, оршин байх, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйгээ, гэрээ хэлцлийн хүрээнд бий болсон бусдад өгөх өр төлбөр тооцоог тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

2. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ -ын үйл ажиллагааны орлогын доод, зарлагын дээд хязгаар, ашиг хуваарилах, орон тоо, цалингийн санг ТУЗ-ийн хурлын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга хянаж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлж жил бүр баталж, биелэлтэд хяналтыг хэрэгжүүлэн ажиллана гэж дүрэмдээ заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлуулах, аймгийн ИТХ-ын 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангаагүй, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталуулан ажиллах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 3. Шинэ Ховд – Жаргалант ТҮК ОНӨААТҮГ 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 29.3 сая төгрөгийн өр үүсгэн ажилласан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” заалтыг зөрчсөн, оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	5195.0					1	5195.0	-	-	-	-
Өр баагдуулан ажиллах	1	29300.0					1	29300				
эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлуулаагүй	1	0,0					1	0,0				
Дүн	3	34495	0	0.0			3	34495				-

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Д.БАЛЖИННЯМ